



**ДУЛААН ШАРЫН ГОЛ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн дугаар зүйлийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн а/875 дугаар удирдамж, 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн а/1018 дугаар удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” ТӨХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралт ёсоор дэмжсүгэй.

2. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ДАВААДОРЖ



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 04 дүгээр сарын 11-ний
өдрийн 15 дугаар тогтоолын хавсралт

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

1. Компанийн дүрмийн 10 дугаар зүйлд “Компанийн хөндлөнгийн аудитыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар хийлгэнэ” гэсэн 10.9 дэх заалтыг хасах;

2. Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7.1-д “...менежментийн ур чадвартай... эдийн засгийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн байх” гэснийг “Эрчим хүчний болон эдийн засаг, хууль, эрх зүйн мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн, 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, удирдлагын зохих дадлага туршлагатай байх” гэж өөрчлөх;

3. Компанийн дүрмийн 12 дугаар зүйлийн 12.2-д “...компанийн ерөнхий нягтлан бодогч... сангийн яамны зөвшөөрөлтэйгээр томилж чөлөөлнө” гэж заасныг “...компанийн ерөнхий нягтлан бодогч... Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн, гүйцэтгэх захирал томилж чөлөөлнө” гэж өөрчлөх;

4. Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7.3-д “ял шийтгэлгүй байх” гэснийг “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ял шийтгэлгүй байх” гэж нэмэх;

5. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлд “Авлигатай тэмцэх газраар хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянуулах Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн томилогддог албан тушаалтнууд болон компанийн нэгжийн удирдлага /салбар, хэлтэс, алба, цех/ түүнээс дээших албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн жагсаалтыг Төлөөлөн удирдах зөвлөл батална” гэсэн 9.1.1 дэх заалт нэмэх;

6. Компанийн дүрмийн 10 дугаар зүйлд “Төлөөлөн удирдах зөвлөл нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, мэргэшсэн нягтлан бодогч, тухайн мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан шаардлагыг бүрэн хангасан иргэнийг дотоод аудиторроор томилох ба дотоод аудитор нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд ажиллана” гэсэн 10.11 дэх заалт нэмэх;